

**XX зууны эхэн үеийн Ар Монгол дахь
гадаадынхны үйл ажиллагаа**

Доктор /Ph/, дэд профессор, Хэрээд Ж. Урангуа /МУИС/

Монголчууд бид 1990-ээд оны эхэн үеэс өнөөг хүртэл гүйцэлдүүлэхээр чадан ядан зүтгэж яваа эрхэм зорилго маань хувийн хэвшил давамгайлсан нээлттэй эдийн засагтай, улмаар гадаадын хөрөнгө оруулалт түлхүү орж ирсэн, эрх зүйт төр бүхий ардчилсан нийгмийг байгуулах явдал билээ. Олон жилийн тэртээд болж өнгөрсөн үйл явдлын баримт сэлтийг сөхөн үзэхүл зах зээлээ аль болох нээлттэй байлгаж, гадаадын капиталыг боломжийн хэмжээгээр чөлөөтэй оруулах бодлогыг бүр Олноо өргөгдсөн Монгол улсын /1911-1915/ үеэс л барьж байжээ.

Монгол Улс нь төрийн тусгаар тогтнолоо сэргээмэгц Хаант Орос улс болон Европ, Азийн томоохон орнуудтай бие дааж харилцах бодлогыг тууштай явуулжээ. Энэ хэрэгт Гадаад Яамны сайд М. Ханддорж, Дотоод Яамны сайд Г.Цэрэнчимэд, Ерөнхий сайд Сайн ноён хан Намнансүрэн нар тууштай зүтгэж байв. 1912-1913 онд Гадаад Яамны сайд Ханддорж нар Петербург хотод очиж Орос Улстай хэлэлцээр хийх зуур тэнд сууж байсан хэд хэдэн улсын элчин сайдын яаманд нот бичиг гардуулж, улс орныхоо тусгаар тогтнолыг зөвшөөрүүлэх, худалдаа-эдийн засгийн харилцаа тогтоох эрмэлзлэлтэй байжээ.

Чин ван Ханддорж нараас Петербург дэх хэд хэдэн улсын элчин сайдуудтай уулзаж учрахаар хэлмэрч илгээсэнд : Ин \Англи\, Фа \Франц\ улсын элчин сайдууд цөм өвчтэй учирч чадахгүй. Билиши, Хэ-лан /Бельги, Голланд/ улсын элчин сайдууд Монголын тусгаар улс болсныг албан ёсоор сонсоогүй тул учирч чадахгүй, Жи-бэн \Япон/ улсын элчин сайдаас : " Та нарыг Англи, Франц улсын элчин сайдуудтай учирсан хойно уулзаж болно" хэмээжээ.

Гагцхүү Да \Герман\ улсын элчин сайд уулзая хэмээсэнд Орос улсын Гадаад Яамнаас Дэ Герман улс болбоос Хятадтай найртай, Оростой муухан харилцаатай тул Монголын тусгаар улс болсныг хүлээхгүй, харин Хятадын төлөө хориглон ятгаж хэлбээс та нарын их хэрэгт харшлалтай болохоор барахгүй манай Орос улсыг, Дэ Мин \Герман\ улстай эвдрэл болоход хүргүүлнэ. Эс учирваас сайн хэмээн дахин давтан хориглов.

Үүнд Да улсын элчин сайдтай учирваас тус хорлол алин болохыг эс мэдэвч Орос улс элдвээр шалтгаацан хориглох байдал илэрхий" гэж хойш цахилгаан утсаар мэдүүлжээ. \УТА, ФА-4, Д-1, х.н.10, х.15\

Монгол Улсын засгийн газар 1912 онд бие төлөөлөгч явуулж, Харбин хотод суух гадаадын зарим улсын консульд Монгол Улсын тусгаар тогтнолыг зарлан мэдэгдсэн нот бичиг хүргэн гардуулжээ.

Энэ тухай архивын баримтад : " Монгол Улс тусгаар тогтнож Богд хаан суусан явдлыг Харбин хотод суух олон улсын элчин консул нарт бичгээр хүргэв. Үүнд: " Ин \Англи\, Фа \Франц\, Мэй \АНУ\, Да \Дани\, Жибэн \Япон\, Билиши \Бельги\ зэрэг зургаан улсын элчин консульд бичгийг хүргэв. Бусад Хэ-лин \Голланд\, Дэ-мин \Герман\, Ау \Австри\ улсын элчин \консуль\ Харбинд үгүй тул олдсонгүй" гэх зэргээр тэмдэглэжээ. \ФА-4.Д.1, х.н. 4, Х.41\.

Эдгээр баримтуудаас үзэхэд шинэ тулгар тогтсон Олноо Өргөгдсөн Монгол Улс нь гадаад орнуудаар үндэсний нэгдэл, тусгаар тогтнолоо хүлээн зөвшөөрүүлж, улмаар харилцаа холбоо тогтоохыг ихэд эрмэлзэж байжээ. Гэвч дээр дурьдсан боогдол саатал их байсан учир Монгол Улсын Засгийн газар Европын орнуудтай шууд харилцах гэсэн идэвхитэй гадаад бодлого нь хэрэгжихгүй сунжирч байлаа.

Монгол Улс нь тэр үед хоёр их хөрш орнуудтай эдийн засгийн хэлхээ холбоотой байлаа. Хаант Орос, Хятад хоёр нь урьдын адил Монголын эдийн засагт өөрийн нөлөөг улам гүнзгийрүүлэх бодлого баримталж байв.

Тэр үе бол өөрсдийг нь зөвхөн шулж мөлжих бодлоготой байсан хятадын худалдаа-мөнгө хүүлэх капиталын ноёрхлоос түр ангижрсан чухал үе байсан билээ. Гэвч хятад худалдаачдын давамгайллыг ийнхүү ганхуулсан явдал тууштай байж чадаагүй бөгөөд Монголын түр сэргэсэн тусгаар тогтнолыг цуцласнаар дахин толгойгоо өндийлгөх болсон юм. Энэ нь үндэсний эрх чөлөөний хувьсгалт хөдөлгөөний дүйвээнээс зугатан явсан 13000 шахам хятад худалдаачид автономитын үед Халхад буцаж ирсний дараахнаас бүр ч идэвхжив. Москвагийн худалдааны экспедицийн мэдээгээр 1912 онд Монголд хятадын худалдааны хэдэн зуун пүүс байснаас 30 нь том пүүс бөгөөд тэдгээрт төлөх нийт өр 10 сая рубль буюу 804600 лан байв. Монголчууд тэр үед зөвхөн хятадууд төдийгүй гадаадын бусад худалдаачдад ч гэсэн асар их хэмжээний өртөй болж хэдийнээ амжсан байжээ.

Тэр үеийн тогтмол хэвлэл болох "Нийслэл Хүрээний сонин бичиг"-ийн 1916 оны сүүлийн нэгэн дугаарт гадаадын хүмүүст төлөх Монголын нийт өр 30 сая лан гэж бичсэн байдаг. Хэрэв Монгол өрхийн дундаж хөрөнгө мянган лан байсан гэж бодвол өрх тус бүрт 500-700 мянган лангийн өр ногдож байгааг И.М.Майский тооцоолон гаргасан нь бий.

Монгол дахь Хятадын пүүсүүдийн үйл ажиллагаа нь зарим нутгаас гар ажиллагаагаар алт ба уулын болор малтан авч байсныг эс тооцвол зөвхөн худалдаагаар хязгаарлагдаж байв. Гэвч ийнхүү хятадууд Монголын эдийн засагт байр сууриа бэхжүүлэх бодлого баримталж байсан нь манай хойт хөрш хаант Оросыг ч гэсэн Монгол руу анхаарлаа хандуулахад өөрийн эрхгүй хүргэсэн юм. Оросын Хаант засаг Чин улсаас тусгаарлах хэрэгт "тусалсны" хариуд Монголд үлэмжхэн эрх дарх олж авч, улмаар Оросын худалдаачид, үйлдвэрлэгчид тус оронд ямар ч хориг саадгүй нэвтэрч, ажиллах болжээ. Ингэснээр хоёр орны харилцаа 1912-1915 онуудад нэлээд өргөжсөн байна. Жишээлбэл, Монгол улс тусгаар тогтнолоо зарлахаас өмнө буюу 1911 онд Хиагт хотоор дамжуулан 11 сая 142 мянган рублийн худалдаа хийж байсан бол, 1915 онд 15 сая 841 мянган рубль болж өсчээ. Энэ өсөлтөд Монгол улсын эрх баригчид сэтгэл ханамжтай байсан бөгөөд, цаашид ч Оростой тогтоосон харилцаагаа өргөжүүлэн хөгжүүлэх нь зүйтэй гэсэн байр суурьтай байжээ. Тухайн үед Монголд ажиллаж байсан Оросын Польш эрдэмтэн В.Котвич нэгэн захидалдаа "Оросын худалдаачин Ф.Москвитин 1912 оны хавар Нийслэл Хүрээнд Орос-Монголын Комиссын агуулахуудын нөхөрлөл гэгчийг байгуулахад Дотоод яамны тэргүүн сайд Цэрэнчимэд, Гадаад яамны тэргүүн сайд Ханддорж, Сангийн яамны тэргүүн сайд Чагдаржав, Шүүх яамны сайд Намсрай, Дотоод яамны дэс түшмэл Хайсан гүн нар оролцож байсан" гэж бичсэн нь дээрхийн илэрхийлэл юм. Үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний нэрт зүтгэлтнүүд ингэж хувь нийлүүлэгчээр элсэн орж, уг нөхөрлөлийн үйл ажиллагааг дэмжиж байсан нь Оростой хийх худалдааны харилцааг улам урамшуулан хөгжүүлэх зорилготой байсан бөгөөд, чингэхдээ юуны урьд Хүрээнд Оросын барааг хүлээн авч, хадгалах орон байр бэлдэхээс ажлаа эхэлжээ.

Гэвч Оросын худалдаа нь 1911-1912 онд Монголоос хөөгдөн гарсан хятад худалдаачдыг орлож чадахгүй байсан бөгөөд монголчуудын хэрэгцээний дөнгөж 30-35 хувийг хангаж байв. Иймээс тус улсын дотор бараа таваарын сүрхий хомсдол бий болжээ. Ингээд Засгийн газарт зайлшгүй шаардлагатай байсан хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилгоор гадаадынханд алтны уурхай түрээслүүлсний төлбөрөө бага хэмжээгээр нэмэгдүүлжээ. Тэр үед нийтдээ 15

алтны уурхай ашиглаж байсан ба тэдгээрт 2500 гаруй хятад, 250 орчим орос, 70 монгол хүн ажиллаж байв. Орос, Франц, Хятадын хөрөнгөтнүүдийн хувь нийлүүлсэн "Монголор" алтны уурхай хамгийн том нь байсан бөгөөд Цэцэн хан, Түшээт хан аймгуудын нутаг дэвсгэр дээр 20 шахам газарт ашиглалтын жижиг уурхайд ажиллуулж байсан тус уурхай 18 жилийн хугацаанд 10471000 мексик доллартай тэнцэх 606 пүү алт олзворлосон байна. Монголын Засгийн газарт нийт орлогооноос 16,5 хувийг өгдөг байсан нь жилийн 350 мянган рубль юм.

Оросоос ирж, санхүүгийн зөвлөхөөр ажиллаж байсан С.А.Козин, түүний орлогч Барон Витте нарын мэдээ баримтаар Монгол улсын төсвийн орлого нь 1913 онд 707418 рубль болж байсны 486720 рубль нь гаалиас, 353300 рубль нь алтны уурхайгаас, 110815 рубль нь газар, загас агнуур зэрэг бусад түрээсээс орж байжээ. Дээрх хүмүүс нь Монгол улсын төсвийн байдлыг судалж үзээд, дотод, гадаад худалдаанаас хураах татварын хэмжээг нэмэгдүүлэх, газар, ашигт малтмал ашиглуулахыг өргөтгөх зэргээр орлогын эх үүсвэрээ нэмэгдүүлэх саналыг албан ёсоор тавьж байсан юм.

Үүний дараахан Монголын эрх баригчид Оросын хөрөнгөтнүүдэд "Монгол үндэсний банк" гэжчиг нээх эрх олгосон байна. Ингэснээр 1914 оны VII сарын 2-ны өдөр Хаант Оросын сайд нарын танхимийн хуралдаанаас Монголд томоохон банк байгуулах талаар гаргасан шийдвэрийг дэмжжээ. Энэ банкны гол зорилго нь Монголын зах зээлийг нөлөөндөө оруулж, Оросын таваарыг Монголд оруулах явдал байсан ба Монголын Засгийн газартай тохирсон анхны хэлэлцээрээр тус банк Монголын албан ёсны байгууллагуудад мөнгө зээлдүүлэх, үндэсний банкны тэмдэгт цаас гаргахад туслах ёстой байв. Гэвч арилжаа ашгийн сонирхол бүхий энэ банк дээрх үүргээ биелүүлээгүй аж. Гадаадын болон дотоодын худалдаачдад олгож байсан зээллэг нь ч нэлээд өндөр хүүтэй байв. Жишээлбэл, Засагт хан аймгийн Наваанцэрэнгийн хошууны нэгэн түшмэл хошууныхаа хэрэгцээнд зориулан 1917 онд Оросын банкаас 3400 рублийг, рубль тус бүрийг сар тутам 1 копейкийн хүүтэйгээр бодож 10 сарын хугацаанд төлж дуусгахаар авч байжээ. Мөнгөн зээллэгтэй холбогдуулан энд нэгэн сонирхолтой баримт дурдахад тус банк нь шинэчлэл хийхэд зориулж зээллэг олгохыг хүссэн Монголын Засгийн газарт татгалзсан хариу өгч байсан ба үүнийг нь тус улсын албаны түшмэд эсэргүүцэн, Нийслэл Хүрэн дэх Оросын ерөнхий Консулд нот явуулж банкны үйл ажиллагааг зогсоохыг шаардаж байжээ.

Хоёр улсын харилцаа энэ мэтээр ямар ч байсан улам өргөжиж, Оросын капитал Монголын зах зээлд төрөл бүрээр нэвтэрч байлаа. Тухайлбал, 1913 онд Монголын Засгийн газар Оросын харьяат Миосей Гальперовт загас агнуулахаар Буйр нуурын хойт эргийг жилд 5000 рублийн хураамжтай, 5 жилийн хугацаагаар түрээслэн өгч, Нийслэл хүрээ, Хиагт хоёрын хооронд хувийн авто шуудан, тээвэр хийх зөвшөөрлийг Чита хотын иргэн Вейнерманд олгож байжээ. Мөн 1914 онд Сэцэн хан аймгийн нутаг Горхийн Бумбагар гэдэг газраас Оросын харьяат Солломонов гэдэг хүн уулын болор гарган авч байжээ. Энэ үйлдвэрт ажиллаж байсан ард Дамдинжавын ярьснаар зун, намрын цагт улирлын чанартайгаар 100 гаруй хүн ажиллаж 30 тэмээ болор ачуулж байсан удаатай ажээ. Түүнээс гадна Владимир, Михайл гэдэг хүмүүс Орхон голын сав газарт уурын тээрэм байгуулах зөвшөөрлийг 1916 онд Засгийн газраас авч байсан бол Оросын хэсэг худалдаачид импортын түүхий эдийг тээвэрлэх зорилгоор 1917 онд Туул гол дээр гүүр тавьж байжээ. Хожим уг Оросууд энэ гүүрээр мал туусан монголчуудаас хураамж авсанд Монголын Засгийн газар эсэргүүцэл илэрхийлж байсан юм.

Орос хөрөнгөтнүүд алтны уурхай, хөнгөн хүнсний үйлдвэр, авто машин, төмөр зам, шуудан холбоо, телефон шугам байгуулах олон санал дэвшүүлж,

зөвшөөрөл олгохыг хүсч байжээ. Оросын фермерийн эзэн Лосокодеников Түшээт хан аймгийн Баатар ван Наваанюндэнгийн хошууны нутаг Мандал гэдэг газар гурилын тээрэм байгуулах, мөн орос худалдаачин Сетухин Носоков Нийслэл Хүрээний ойр Туул голд ноос угаах газар байгуулах, хөрөнгөтөн Попов, Набрадов нар Өгий нуур, Дэлгэрмөрөнд загас шүүрдэх эрх олгохыг хүсч байжээ.

1912 онд Дээд Үд хотоос хэвлэлийн машин авч жижиг оворын хэвлэх үйлдвэрийг Нийслэл Хүрээнд нээн ажиллуулсан. Бас орос хөрөнгөтөн Горбоносов 1913 онд Хөвсгөл нуурт "Монгол" нэртэй жижиг усан онгоц барьж ашиглалтад оруулсан. 1914 оноос Монголд Манжуураас салаалж, төмөр зам байгуулах санал гарч байсан зэрэг шинэ зүйлүүд гарч байжээ.

Олноо Өргөгдсөн Монгол Улсын үед тус орны Сангийн яаманд Оросын Сангийн яамны зөвлөх, төлөөлөгч нар ажиллан Монголын эдийн засаг, санхүүгийн байдлыг судлан, санхүүгийн эх үүсвэр бий болгох, ялангуяа Хаант Орос улсаас зээл авах, түүнийг эргүүлэн төлөх боломжийг судлах зэрэг ажлыг хийж байсан. Хаант Оросын засгийн газартай холбоотой байсан нь Оросын зах зээлд нэвтрэх, оросоос зээл авах, төсвөө бэхжүүлэх, соёл боловсролыг хөгжүүлэх, тариалангийн аж ахуй, мал эмнэлэг, уурхайн баялаг ашиглах зэрэгт нааштай нөлөө үзүүлсэн ажээ.

Гэвч дэлхийн нэгдүгээр дайн эхэлснээр Монгол дахь Оросын худалдаачдын нөлөө суларч, бараа таваар орж ирэх нь эрс багассан байна. Энэ завсар оросуудын үлдээсэн орон зайг япончууд тун шалмаг дүүргэж эхэлжээ. Тэд Монголын зах зээлийг ихэд сонирхон Нийслэл Хүрээнд төлөөлөгчөө суулган. Өнөөг хүртэл хадгалагдан үлдсэн "Хүрээний тухай илтгэл бичиг"-ийг Мицуй Буссан пүүсийн төлөөлөгч хоёр ч хүний тухайн үеийн Хүрээний тухай илтгэл бичиг өнөөг хүртэл хадгалагдан үлджээ. Умард Хятадад салбартай байсан уг пүүс Ар Монголд нэвтрэх арга замыг удтал идэвхтэй хайсан бөгөөд 1917 оны наймдугаар сард Чуулалт хаалга-Хүрээний хооронд Америкийн "Монголиан Трейдинг Компани" пүүс автомашинаар шууд зорчих зам нээсэн нь тэднийг зорилгоо биелүүлэх боломжтой олгосон тухай дээрхи бичигт дурдсан байдаг.

Монголын зах зээлийг бусад орнууд ч мөн ихээхэн сонирхож байв. Энэ үед дээр дурьдагдсан орнуудаас гадна Англи, АНУ, Герман, Франц, Бельги, Дани, Чех, Норвег, Турк зэрэг Европын олон орны худалдааны хүмүүс, үйлдвэрийн эзэд Монгол орныг хувиараа сонирхож, хөрөнгө оруулах, уурхай үйлдвэр нээн байгуулах, газар нутгийн судалгаа, ашигт малтмал хайх ажлыг хийх болжээ.

Английн засгийн газар 1914 оны IV сарын 18-ны өдөр Петрбургт байсан өөрийн элчин сайд Лорд Бьюкээр дамжуулан, Монголд Оросын иргэдийн эдэлж байгаа шиг таатай нөхцлийг Британи иргэдэд эдлүүлж, гадаад Монголыг улам "нээлттэй" болгохыг шаардаж байжээ. Мөн англичууд Монголд хар тамхины худалдааг 5 жилийн хугацаагаар хийх эрх олгох хүсэлтийг Засгийн газарт бичгээр тавьж үндсэндээ зөвшөөрсөн хариу авч байсан. Харин ийнхүү зөвшөөрсөн явдлыг Хаант Оросын Засгийн газрын консул үл таашаан эсэргүүцэж байсан болно.

Тэр үед Баруун Хүрээний тэмээн захын их "Андерсен ба Майер" пүүс, хоёр америк хүнээс гадна 20 орчим хятад монгол хөлсний ажилчидтайгаар үйл ажиллагаа явуулж, жилдээ дөрвөн мянга орчим адууг Хятад руу гарган, ялангуяа уралдааны морьдыг сонгон Бээжин, Тяньцзин, Шанхайн морин тойруулгад арав дахин илүү үнээр зарж, ашиг олдог байжээ. Америкийн өөр нэг "Монголиан Трейдинг Компани" пүүс нь Чуулалт хаалга-Хүрээний хооронд сард гурван удаа авто тээвэр хийдэг, Хятадын Засгийн газар ч үүнийг нь зөвшөөрсөн байв. Учир нь тэд Монголоос малын арьс шир, ангийн үсийг жил бүр хэдэн арван мянгаар нь экспортлон гаргадаг байжээ.

Монголын түүх

Америкчууд Монголын Засгийн газартай ийнхүү улам ойртохын тулд Богд Жибзундамба хутагтад “форд” бэлэглэхээс аваад санхүүгийн туслалцаа үзүүлж байв. Жишээлбэл, Сангийн яамны тэргүүн сайд гүн лам Лувсанбалдан “Андерсен ба Майер” пүүсийн чуулалт хаалганд сууж байсан эрхлэгч Андерсенд тусгай элч илгээн засгийн албанд хэрэглэхээр Дундад Иргэн Улсын мөнгө төгрөг 30 мянгыг нэг жилд 100 төгрөг тутмаас 8 төгрөгийн хүүтэйгээр 6 сарын баталгаа гарган зээлж байжээ.

XIX зууны сүүлчийн хагаст Суэцийн суваг нээгдэж, Манжуурын төмөр зам ашиглатад орсноос хойш Монголын нутаг дээгүүр дамжин тээвэрлэгдэх ачааны хэмжээ буурсан боловч, Хятад, Орос болон баруун Европын орнуудаас Монголд бараа таваараа шууд оруулах, түүхий эдийг гаргах нь харин ч нэмэгджээ. 1911 онд “Вестник Азии” сэтгүүлд бичсэнээс үзвээс зөвхөн орон нутгаас 1 сая 500 мянган пүү ноос Туньцзинээр дамжин Европ, Азид тээвэрлэж байжээ. Англи, Германы хотуудаас барааг Тяньцзин хүртэл усан замаар тээвэрлэж, тэндээс Монголд ирүүлэх нь Оросоор дамжуулан хуурай замаар тээвэрлэхээс бараг хоёр дахин хямд байлаа. Түүхий эдийг зөөхөд ч мөн хямд тусч байв. Иймд Чуулалт хаалганы чиглэл нь тэр үед зөвхөн Хятад төдийгүй, Европын улстай худалдаа хийх гол зам болж, Монголын тээврийн урсгалд тэргүүн байр эзлэх болсон байна. Хаалганы чиглэлд монгол нутгийн өнцөг булан бүрээс шахам хөсөг явдаг байсны дотор Хүрээ-Хаалганы хамгийн их ачаалалтай байжээ. 1913-1914 оны гаалийн бүрэн бус данснаас барагцаалан үзвэл тэр үед жил бүр 80 мянгаас доошгүй хөсөг хөдөлж, 2,5-3,0 сая орчим пүү ачааг нааш, цааш тээвэрлэж байсан бололтой. Энэ нь тэр үеийн нийт ачаа эргэлтийн 70 орчим хувь юм.

1913 оны VIII сард Английн худалдаачин Пейвер Нийслэл Хүрээний газар худалдааны пүүс нээх \ФА-4,Д.1,х.н.19,х.105\ мөн Английн иргэн Хинада Их Хүрээний ойр худалдааны пүүс нээх байшин хашаа бариулах газар түрээслэн олгуулж өгөх, Герман улсын иргэн Ригта Хиагтын Майма хотын газар байгаа хашаа байшинг сэлбэн засаж шинэ гэр болгоод “сүүдэр наадам” \кино\ гаргаж олонд үзүүлье гэсэн \ФА-1,д.1, х.н.28\ саналыг Засгийн газарт тавьж байжээ.

Австри улсын иргэн Горано 1914 оны XI сард Хүрээний зүүн этгээдэд худалдааны дэлгүүр нээх газар олгохыг хүссэн, Норвегийн худалдаачин Манна хашаа байшин барих газрын зөвшөөрөл олгох, Түркийн иргэн Тамзан Пиудор башаа хашаа барих газрын зөвшөөрөл хүсэхэд дээрхи хүмүүсийн хүсэлтийг ёсоор болгосон зөвшөөрөл олгосон тухай баримт архивд нилээд буй.

Өгүүлэн буй үед Хүрээнд Австрийн “Генрих”, Да Хүрээний Наймаа хотод Норвегийн “Мамия” зэрэг өөр олон гадаадын пүүс, үйлдвэрлэгчид ажиллаж байсныг дурдахгүй өнгөрч болохгүй. Байнга оршин сууж байсан гадаадын харъяатууд ч олон байв. Тухайлбал, талх, чихэр, бурам үйлдвэрлэх газрыг грекийн харъяат Ф.Корифиди, архи, пивоны заводыг Австрийн иргэн В.Ф.Генрих, Америкийн бараа таваар худалдаалах дэлгүүрийг Германы иргэн Хакман нар эрхэлж, “Биржа”, “Русь” зэргийг нь харин оросууд эзэмшиж байлаа.

Ийнхүү XX зууны эхэн үед Монгол оронд гадаадын капитал чөлөөтэй орж ирж байжээ. Монголд бизнэс эрхлэн оршин сууж байсан эдгээр хүмүүс нь тус оронд өнө, дорнын соёл нэвтрэхэд үүрэг гүйцэтгэсэн нь дамжиггүй. Тэр үед Орос улсын мэргэжилтэн багш нарыг урин авчирч хичээл заалгаж байв. Тухайлбал: эрдэмтэн Ц.Жамсранов, Даш, Абшаев, Ванпилова, Эрхүү хотод багшилж байсан Англи багш Уйдинг зэрэг хүмүүс байв. Эдгээр хүмүүсийн заримыг “...харьяат сургуулийн хөвгүүдэд бичиг үсэг заан сургах нь маш хичээнгүй болгоомжтой, ер залхууран хойргоших санаагүй сайнаар

боловсруулан сургаж бүхий..." учир Богд гэгээн Эрдэнийн очир одонгоор шагнаж байжээ.

Мөн Солонгос улсын иргэн эмч И Тэ Жүнь Монголын засгийн газарт ихээхэн нэр хүндэй төдийгүй жирийн ард олны хайр хүндэтгэлийг хүлээсэн хүн байсан бөгөөд Тэргүүн зэргийн Эрдэнийн очир одонгоор шагнадаг байжээ.

Ийнхүү Монгол улсад амьдарч байсан гадаадынхан тус оронд оюуны болон хүмүүнлэгийн хөрөнгө оруулалт хийж байсан нь Олноо Өргөдсөн Монгол Улс тухайн үедээ гадаадын улс орнуудаар төдийгүй хувь хүмүүсээр өөрийн тусгаар тогтнол, баримталж буй байр сууриа дэмжүүлэх, тэдэнтэй ойртон нягтрах чиглэл бримталж байсныг дээрхи бүх баримтууд харуулж байна. Мөн түүчлэн л зах зээлээ аль болох нээлттэй байлгаж, гадаадын капитлалыг боломжийн хэмжээгээр чөлөөтэй оруулах бодлого баримталж байжээ.

Ном зүй.

1. Ар Монгол дахь Хятадын худалдаа-мөнгө хүүлэл /1751-1911/ Хэвлэлд бэлтгэсэн. А.Очир, Г.Дашням. УБ., 1988 он.
2. БНМАУ-ын түүх. Гутгаар боть. УБ., 1968 он.
3. Батбаяр.Ц. Кодама Мицүи пүүс, Хүрээнд байсан Япончууд.1911-1921 УБ.,1993
4. Баттөр.Ж. XX зууны Монгол-Солонгосын харилцаа. Тэргүүн дэвтэр. /1910-1930-аад он/.
5. "Вестник Азии" 1911 г.
6. В.Котвичийн хувийн архиваас олдсон Монголын түүхэнд холбогдох зарим бичиг.УБ.,1972
7. Жамсран.Л. Монголын сэргэн мандалтын эхэн. УБ., 1992 он.
8. Златкин.М.Я. Очерки новой и новейшей истории. Монголии. М., 1957 г.
9. "Московские ведомоста" 1913 г.
10. Нацагдорж.Ш. Монголын феодализмын үндсэн замнал. УБ., 1978 он.
11. Нийслэл хүрээний сонин бичиг. 1917 он.
12. Матский И.М. Монголия наануне революции. М., 1959 г.
13. "Страны Востока в политике" России в XIX-начале вв. Ир., 1986 г.
14. "Торгово-промышленная газета" 1912 г.
15. Пунцагноров. Ц. Монголын автономитын үеийн түүх. УБ., 1955 он.
16. Идшинноров. Ш. XIX-XX зууны зааг дахь Монголын нийгэм-эдийн засгийн байдлынзарим асуудал. УБ., 1986 он.
17. Урангуа.Ж. XX зууны үеийн Ар Монгол дахь шинэтгэл. УБ., 1997 он.
18. Энхжин.С. Монголын төр, үндэсний сэргэн мандалт. УБ., 1999 он.
19. Ширэндэв.Б. Монгол ардын хувьсгалын түүх. УБ., 1969 он.
20. Шинэ толь. 1914 он.